



**ХЭНТИЙ АЙМГИЙН  
ЦЭНХЭРМАНДАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2025 оны 09 сарын 06 өдөр

Дугаар A/86

Модот

**Цэцэг өвчнөөс урьдчилан сэргийлэх  
дархлаажуулалтын ажлыг зохион байгуулах  
тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дүгээр зүйлийн 66.1, мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4, 9.5, 9.6, 9.7, 9.8 дахь заалт, Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2025 оны A/207 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Цэцэг өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын арга хэмжээг сумын хэмжээний бүх хонь, хурга малыг хамруулан 2025 оны 09 дүгээр сарын 05-наас 25 хоногийн хугацаанд мал эмнэлгийн үйлчилгээний нэгжүүд шуурхай зохион байгуулсугай.

2.Дархлаажуулалт хийх ажлыг малчидад урьдчилан мэдэгдэж, мал сүргийг бэлэн байлгуулах, тарилгын хашаа, хоолойг бэлтгүүлэн бэлэн байдлыг хангуулж ажиллахыг Багийн Засаг дарга нарт даалгасугай.

3.Урьдчилан сэргийлэх дархлаажуулалтад мал сүргээ бүрэн хамруулаагүй, хамруулахаас зайлс хийсэн малчид мал бүхий иргэд, заавар журмыг баримтлаагүйн улмаас малын өвчин гарах нөхцөлийг бүрдүүлсэн этгээдэд хуулийн дагуу арга хэмжээ тооцож ажиллах, дархлаажуулалтанд шаардлагатай вакцин татан авах, мэргэжил арга зүйн заавар зөвлөмжөөр хангах, гүйцэтгэлд хяналт хийн ажиллахыг мал эмнэлгийн улсын байцаагч (П.Ганчимэг)-т үүрэг болгосугай.

4.Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахын Засаг даргын Тамгын газрын дарга (Ү.Ичинхорлоо)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

А.МӨНХ-ОРГИЛ